

**МОНГОЛ УЛСЫН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ
ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
16 ДУГААР ТОЙРОГ**

**БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
БӨХЧУЛУУН ОВОГТОЙ ЧУЛУУНБААТАРЫН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 ОН

ХОВД АЙМАГ



МОНГОЛ УЛСЫН АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН 16 ДУГААР ТОЙРОГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ **БӨХЧУЛУУН** ОВОГТОЙ **ЧУЛУУНБААТАРЫН**
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.07.24

Ховд аймаг

Нэр дэшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа УИХ-аар 2016 онд баталсан "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030", мөн 2010 онд баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", 2001 онд баталсан "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ийн хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилгод тулгуурлан, Аймаг, Нийслэл, Сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 3.1.2, 4.4, 6.4, 30, 31.3.9 дүгээр заалтуудыг удирдлага болгон боловсрууллаа.

БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 1.


НИЙГМИЙН ХАМГААЛАП, ЭРҮҮ.П МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТАЙ, ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ХҮНИЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ОНОВЧТОЙ БОДЛОГО, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, УДИРДЛАГА МЕНЕЖМЕНТИЙН ШИЛДЭГ ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ ЗАМААР ДУНДАЖ НАСЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭН ХҮН АМЫН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИНЭ.

Зорилт 1. Эмнэлгийн түслэмж үйлчилгээний хүртээмж, чанарыг олон улсын стандартад хүргэж, хүн амын өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаа голлох өвчлөлийн түвшинг улсын дунджаас бууруулна.

- 1.1 Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч, сувилагчдын тоог стандартад хүргэж, нэг эмч, сувилагчид ноогдох ачааллыг бууруулах замаар эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлнэ.
- 1.2 Бүсийн оношлогоо эмчигээний төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг өндөр хурдны интернэт, орчин үеийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг эрчимжүүлж, зайн оношлогоог нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.3 Аймаг, сумдын хэмжээнд явуулийн бүх төрлийн оношлогоо хийх нөхцлийг бүрдүүлнэ.

Зорилт 2. Эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд төр болон төрийн бус байгууллага, хувь хүн, гэр бүл, хамт олны июдэхитэй оролцоог нэмэгдүүлнэ.

- 2.1 Хүүхдүүдийг бага наснаас нь эхлэн бие бялдарыг чийрэгжүүлэн дархлаажуулах, эрүүл мэндийн зөв зан үйлд төлөвшүүлэх, хүүхдийн амны хөндийг эрүүл байлгахад чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.2 Сэтгэл зүйн болон эрүүл мэндийн зөвлөх үйлчилгээ, эрүүл амьдралын дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн эрүүл мэндийн кабинетуудыг сум дундын болон сум, өрхийн эрүүл мэндийн төвийг түшиглэн байгуулна.



БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 2.

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЖ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ӨНДӨР МЭРГЭШСЭН, БҮТЭЭЛЧ ЧАДАВХИТАЙ БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХЫГ ДЭМЖИНЭ.

Зорилт 3. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлж үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэнэ.

- 3.1 Ерөнхий боловсролын бүх сургууль, цэцэрлэгийн гадаад болон дотоод орчинг камержуулж гэмт хэрэг, эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдүүлнэ.
- 3.2 Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль бүрт бага насны хүүхдийн онцлогт нийцсэн сургалтын орчинг бүрдүүлж, сургалтын хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.3 Ерөнхий боловсролын сургуулиудыг өндөр хурдны интернетэд бүрэн холбож, цахим сургалтын систем, номын сан, мэдээллийн сантай болгоно.
- 3.4 Ерөнхий боловсролын сургуулиудад түшиглэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсрол эзэмших, нийгэмших нөхцөлийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах багшлах боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.5 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлж, хүүхдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулна.
- 3.6 Өндөр хөгжилтэй орноос боловсролын салбарт сайн дурын ажилтан болон сургагч багш нарыг ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх талаар дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилтай орлоготой, бүтээлч иргэдийг бий болгох замаар хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлж, гадагшаа чиглэсэн шилжилт хөдөлгөөний багасгаж, ядуулыг бууруулах арга замыг ирэлхийлнэ.

- 4.1 Аймгийн хөгжлийн стратеги, бодлогын чиглэл болох хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль хамгаалал, усны инженер, уул уурхай, өнгөт металлурги, газрын тос, транзит тээвэр, ложистикийн инженер мэргэжлээр өндөр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, тэднийг тогтвор суурьшилтай ажиллах ажлын байр, орон сууц, амьдралын нөхцөлөөр хангаж, гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулна.
- 4.2 Шаардлагатай чиглэлээр туршлага, ур чадвар бүхий мэргэжилтэн, боловсон хүчнийг тодорхой хугацаанд урьж ажиллуулах, залуу ажилтнуудыг дагалдуулан сургах замаар тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 4.3 Мэргэжилтэй залуучууд, төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй ажил, мэргэжилд зуучилах, эзэмшсэн мэргэжлээрээ бизнес, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих, мөн оюутнуудад суралцах хугацаандаа ажил хөдөлмөр хийж туршлагажих, орлого олоход нь дэмжлэг үзүүлэх.
- 4.4 Орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээ бий болгох, хөрш зэргэлдээ улс, бусад аймгуудад үйл ажиллагаа явуулахад нь бодлогоор дэмжлэг үзүүлнэ.

8417143592
ПНОА0073 9066454



БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 3.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЯЛАГ НӨӨЦӨД ТУЛГУУРЛАН ЭКО-ОРГАНИК, ТЕХНОЛОГИ ШИНГЭЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛДВЭРЛЭПИЙГ ХӨГЖҮҮЛНЭ.

Зорилт 5. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг бүс нутгийн онцлог, уламжлалт чиг хандлага, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж, мал аж ахуйн салбарын бүтээмжийг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлнэ.

- 5.1 Мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулах, халдваргүйжүүлэх, вакцинжуулах ажлыг эрчимжүүлнэ.
- 5.2 Мах хадгалах сум дундын зоорь байгуулахад бодлогоор дэмжинэ.

Зорилт 6. Хүнс болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний бүрэн боловсруулах хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх, бүтээгдэхүүнээ экспортлоно.

- 6.1 Хэрэглээний гол нэрийн барааны дотоодын үйлдвэрлэл, импортын судалгааг Ховд аймгийн хэмжээнд жил бүр гүйцэтгэж, мэдээллийн сан бүрдүүлэн үйлдвэрлэл эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад түгээдэг болно.
- 6.2 Ховд аймгийн дотоодын үйлдвэрүүдийн эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг тус аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа дотоод гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компани, сургууль, цэцэрлэг болон бусад төрийн үйлчилгээний байгууллагуудад нийлүүлэхийг дэмжинэ.
- 6.3 БНХАУ, ЯПОН, ОХУ-ын мах, махан бүтээгдэхүүний импортлогч байгууллагын төлөөлөгчийг Баруун бүсийн тулгуур төв Ховд хотод ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 6.4 Дотоодын нөөцөд түшигпэпян эрүүп мэнд, гоо сайхны болон бусад “эко” бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх биотехнологи, био химийн үйлдвэрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулахыг дэмжинэ.

БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 4.

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН НӨӨЦ, ТҮҮНИЙ НӨХӨН СЭРГЭХ ЧАДАВХИД НЬ ТОХИРУУЛАН АШИГЛАЖ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ ЗАМААН БАЙГАЛИЙН УНАГАН ТӨРХИЙГ ХАДГАПНА.

Зорилт 7. Хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулахад хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөллийг багасгана.

- 7.1 “Хүрэн эдийн засаг”-аас “Ногоон эдийн засаг”-т шилжүүлэх бүхий л арга хэмжээ, төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана. Энэ чиглэлийн бизнес, үйл ажиллагааг тодорхой түвшинд татвараас чөлөөлнө.
- 7.2 Ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд шаардпагатай хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар ногоон эдийн засагт шилжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлнэ.
- 7.3 Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй эвдэрсэн газар, экологийн хохирлыг нөхөж төлүүлнэ. Уул уурхайн ашиглалт эхлүүлж байгаа бүх үйл ажиллагаанд хариуцлагатай уул уурхай, экологийн нөхөн сэргээлийн асуудлыг нэн тэргүүнд “үүрэг” -жүүлнэ.
- 7.4 Ирээдүйн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бодитойгоор үнэлж, хүн-байгалийн тогтолцооны уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бүрдүүлэхэд анхаарна.

Зорилт 8. Хамгаалалтанд авах шаардлагатай экосистем, биологийн чухал ач холбогдолтой газруудыг улсын тусгай хамгаалалтад авна.

- 8.1 Олон улсад тусгай хамгаалалттай газар нутгийг сонгон авах шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан, хамгаалалтад авах шаардлагатай газруудыг судалгаагаар нарийвчлан тогтоох ажлыг олон улсын болон Ховд их сургуулийн эрдэмтэн судпаачид, байгаль орчны судалгаа, шинжилгээний мэргэжлийн байгууллагатай хамтран хийнэ.
- 8.2 Дэлхийд болон Монголд нэн ховор, ховор амьтан, ургамлын түлхүүр экосистем бүхий нутгийг тусгай хамгаалалтад авч, 2025 онд аймгийн улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувь болгоно.

БОДЛОГЫН ЧИГЛЭЛ 5.

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОВЧТОЙ БОДЛОГО ЯВУУЛАХ, ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙГ "ТОДОРХОЙ ТОДРУУЛЖ" БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫГ ДЭМЖИНЭ.

Зорилт 9. Эдийн засгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ.

- 9.1 Хөрөнгө оруулалтын орчныг тодорхой, тогтвортой болгоно. Хөрөнгө оруулалтад учирч байгаа хүндрэлийг арилгах, өрсөлдөх боломжийг нэмэгдүүлэхэд анхаарна.
- 9.2 Уул уурхай, материал баялагт шүтсэн өрөөсгөл эдийн засгийг уламжлалт мал аж ахуй, үндэсний үйлдвэрлэл, мэдлэгт суурилсан, байгальд ээлтэй эдийн засагтай хослуулах зохистой бодлогыг дэмжинэ.
- 9.3 Эрчим хүч, шатахууны хараат байдлыг багасгах, үнийг зохистой хэмжээнд барих зорилгоор газрын тос боловсруулах үйлдвэрийг Баруун бүсийн тулгуур төв Ховд хотод байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 9.4 Эдийн засгийн чиглэлээр баруун бүсийн тулгуур төв болгох ажлыг бодлогоор дэмжинэ.
- 9.5 Аялал жуулчлалын чиглэлээр дотоод болон гадаадын жуулчдыг татаж төвлөрүүлэхийг бодлогоор дэмжиж ажиллана.

БӨХЧУЛУУН ОВОГТОЙ ЧУЛУУНБААТАР

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

Хаяг: Ховд аймаг, Жаргалант сум, Наран багийн 26-8 тоот

Регистерийн дугаар: /ПЮ79092214/

Холбоо барих: 99228425, 80432121

Емэйл: cbukhchuluun@gmail.com

